

## ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

### УЛААНСАН ХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2023 он	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Лидер экаунт аудит” ХХК Утас: 88112654, 88472789 Цахим хаяг: <a href="mailto:leaderaudit.20@gmail.com">leaderaudit.20@gmail.com</a>
----------------------------	--



# “ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2023 оны 8. сарын 17. өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,  
Төмөрчний гудамж - 8, 405 тоот  
Утас: +976 7711-4519, 88472789, 88112654  
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### УЛААНСАН ХК-ИЙН УДИРДЛАГАД

#### *Дүгнэлт*

Бид Улаансан ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бурдсэн санхүүгийн тайланда аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Улаансан ХК 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### *Дүгнэлтийн Үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

#### *Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага*

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шудрага бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг, хариуцлагатай байна.

### **Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ анgid эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулагад санал өгөх хангалттай зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг менежентийн захидалд тусгасан болно.

### **Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Улаансан ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Лидер экаунт аудит ХХК  
Захирал П.Шаравхорол

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**УЛААНСАН ХК-ИЙН  
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)**

Үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31	(мян.төгр)
<b>ХӨРӨНГӨ</b>				
<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрнгө	3.1	24.5	24.5	
Дансны авлага		-	-	
Татвар, НДШ-ийн авлага		-	-	
Бусад авлага		-	-	
Бараа материал		-	-	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-	-	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>24.5</b>	<b>24.5</b>	
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
Үндсэн хөрөнгө	3.2	26,987.4	26,987.4	
Биет бус хөрөнгө		-	-	
Урт хугацаат хөрөнгө оруулалт		-	-	
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>26,987.4</b>	<b>26,987.4</b>	
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>27,011.9</b>	<b>27,011.9</b>	
<b>ӨР ТӨЛБӨР</b>				
<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
Дансны өглөг		-	-	
Татварын өр		-	-	
НДШ-ийн өглөг		-	-	
Бусад богино хугацаат өр төлбөр		-	-	
Хүүний өглөг		-	-	
Урьдчилж орсон орлого		-	-	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>	<b>-</b>	
<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
Урт хугацаат зээл	3.3	7,320.1	7,320.1	
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-	
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>7,320.1</b>	<b>7,320.1</b>	
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>7,320.1</b>	<b>7,320.1</b>	
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>				
Хувийн өмч	3.4	5,595.2	5,595.2	
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		-	-	
Эзийн өмчийн бусад хэсэг	3.5	227,362.6	227,362.6	
Хуримтлагдсан ашиг/алдагдал		(213,266.0)	(213,266.0)	
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>19,691.8</b>	<b>19,691.8</b>	
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨМЧИЙН ДҮН</b>		<b>27,011.9</b>	<b>27,011.9</b>	

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

**УЛААНСАН ХК-ИЙН  
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН  
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)**

(мян.төг)

<b>Үзүүлэлт</b>	<b>Тод</b>	<b>Өмнөх он</b>	<b>Тайлант он</b>
<b>Борлуулалтын орлого</b>	3.6	-	-
Борлуулалтын ертөг		-	-
<b>Нийт ашиг(алдагдал)</b>		-	-
Хүүний орлого		-	-
Ногдол ашгийн орлого		-	-
Бусад орлого	3.7	5,825.0	-
Борлуулалт маркетингийн зардал		-	-
Ерөнхий удирдлагын зардал		-	-
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал	3.8	5,821.8	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-	-
Гадаад валютын ханшийн зерүүний олз (гарз)		-	-
Бусад ашиг/алдагдал/		-	-
<b>Татварын өмнөх ашиг(алдагдал)</b>		<b>3.2</b>	-
Орлогын татварын зардал	3.9	-	-
<b>Татварын дараах ашиг(алдагдал)</b>		<b>3.2</b>	-
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)</b>		<b>3.2</b>	-

## 2.3 Аудит хийсэн эздийн өмчийн өөрчлөлтийн тайлан

**УЛААНСАН ХК-ИЙН  
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)**

(мян.төг)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриатлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,595.2</b>	<b>227,362.6</b>	<b>(213,269.2)</b>	<b>19,688.6</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	<b>5,595.2</b>	<b>227,362.6</b>	<b>(213,269.2)</b>	<b>19,688.6</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	3.2	<b>3.2</b>
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,595.2</b>	<b>227,362.6</b>	<b>(213,266.0)</b>	<b>19,691.8</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	<b>5,595.2</b>	<b>227,362.6</b>	<b>(213,266.0)</b>	<b>19,691.8</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	<b>19,691.8</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,595.2</b>	<b>227,362.6</b>	<b>(213,266.0)</b>	<b>19,691.8</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**УЛААНСАН ХК-ИЙН  
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)**

(мян.төг)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>5,825.0</b>	-
Бараа борлуулсан, үйлчилгээний орлого	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	5,825.0	-
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>5,821.8</b>	-
Хөрөнгийн биржийн хураамжийн зардал	-	-
Хувьцааны тархалтын мэдээ	-	-
Зар сурталчилгаа	-	-
Бусад	5,821.8	-
Газрын төлбөр	-	-
Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	-
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3.2</b>	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хөрөнгө оруулалт	-	-
Хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд	-	-
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрл бүрийн хандив	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	-	-
Зээл, өрийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>Валютын ханшийн зөрүү</b>	-	-
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>3.2</b>	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21.3	24.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24.5	24.5

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### ТОДРУУЛГА 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Регистрийн дугаар :	2002116
Үйл ажиллагаа:	Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа
Гүйцэтгэх захирал:	Г.Лхагвасүрэн
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид:	Тулгат Чандмань Баян ХХК 10.2 хувь Ганболд Лхагвасүрэн 63.9 хувь
Дүрмийн сан:	5,595.2 мянган төгрөг
Компанийн хаяг:	Увс аймаг, Баруунтуруун сум
Утас:	99007964

### ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

#### 1. СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагаа

Баримталсан стандартын талаар: Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (СТОУС) болон Сангийн сайдын 361 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн байгууллагад мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” аргачлалын дагуу бэлтгэсэн.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагналын валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг байна. Компанийн санхүүгийн тайлангуудаа үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн байна.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн байна.

#### 2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодолгууд

##### 2.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Үүнд бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, хадгаламж зэргийг хамруулна.

##### 2.2 Авлага

Компанийн авлага нь ажил, үйлчилгээг зээлээр борлуулж, төлбөрийг худалдан авагч болон бусад этгээдээс нэхэмжилж буй мөнгөний дүн юм.

## **2.3 Бараа материал**

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно. Бараа материалын өргтийг жинлэсэн дундажийн өргтийг аргаар тооцох бөгөөд уг бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан зардлуудыг өртөгт шингээнэ.

## **2.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анхны удаа өргөөр нь бүртгэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах тайлант үед үндсэн хөрөнгийг түүний өргөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

• Барилга байгууламж	25-40
• Тоног төхөөрөмж	10 жил
• Тээврийн хэрэгсэл	10 жил
• Тавилга, эд хогшил	5-10 жил
• Компьютер, тоног төхөөрөмж	2-3 жил

Ашиглах эрхийн хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлоходо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ. Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

## **2.5 Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийг анхны өргөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд дараа үеэдэд түүний өргөөс нь хуримтлагдсан хорогдуулга, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр илэрхийлдэг. Биет бус хөрөнгийн ашиглагдах хугацааг дараах байдлаар тогтооно.

• Программ хангамж	Лизенцийн хугацаанд
• Газар эзэмших эрх	Эрхийн хугацаанд

## **2.6 Өр төлбөр**

Харилцагч байгууллага, хувь хүнээс авсан бараа, ажил, үйлчилгээ авсныхаа төлөө тэдэнд мөнгө эсвэл бусад хөрөнгөөр төлбөр төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн хариуцлага бөгөөд ирээдүйд төлөгдөх өргөөрөө хэмжигдэнэ.

## **2.7 Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл**

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж төгрөг, юалютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгө хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлэн тайлагнадаг. Ажил гүйлгээнээс үүссэн валютын ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Жилийн эцсийн валютын ханшаар хөрвүүлсэнтэй холбоотой олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Зах зээлийн үнээр хэмжигдэгээс бусад мөнгөн бус

зүйлсийг ажил гүйлгээ хийгдсэн өдрийн түүхэн ханшаар бүртгэж, тайлант жилийн эцэст тэгшигтгэл хийхгүй.

## **2.8 Хувьцаат капитал**

Энгийн хувьцаа нь хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгийг харуулдаг бөгөөд хувьцааны нэрлэсэн үнэ болон хувьцааны тоо ширхэгийг санхүүгийн тайланд толилуулдаг.

## **2.9 Орлого**

Бараа, ажил, үйлчилгээ борлуулсны орлого, хөрөнгө бусдад ашиглулсны орлогыг хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрдөг.

## **2.10 Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал**

Санхүүгийн орлого нь хүүний орлогоос бүрдэх бөгөөд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд бүртгэгдэнэ. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд бүртгэгдэнэ.

## **2.11 Зардал**

Зардлыг нягтлан бодох бүртгэлийн аккруэль суурьт зарчмын дагуу эдийн засгийн ирээдүйн үр ашгийг хэмжиж болохуйц хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

## ТОДРУУЛГА 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 3.1 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(мян.төг) Эцсийн үлдэгдэл
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банкны харилцах	-	-
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	24.5	24.5
<b>Нийт дүн</b>	<b>24.5</b>	<b>24.5</b>

### 3.2 Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(мян.төг) Эцсийн үлдэгдэл
Үндсэн хөрөнгө	26,987.4	26,987.4
<b>Нийт дүн</b>	<b>26,987.4</b>	<b>26,987.4</b>

### 3.3 Урт хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(мян.төг) Эцсийн үлдэгдэл
Урт хугацаат зээл	7,320.1	7,320.1
<b>Нийт дүн</b>	<b>7,320.1</b>	<b>7,320.1</b>

### 3.4 Эздийн өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(мян.төг) Эцсийн үлдэгдэл
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,595.2	5,595.2
<b>Нийт дүн</b>	<b>5,595.2</b>	<b>5,595.2</b>

### 3.5 Эздийн өмчийн бусад хэсэг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(мян.төг) Эцсийн үлдэгдэл
Эздийн өмчийн бусад хэсэг	227,362.6	227,362.6
<b>Нийт дүн</b>	<b>227,362.6</b>	<b>227,362.6</b>

### 3.6 Борлуулалтын орлого болон борлуулалтын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	(мян.төг) Тайлант он
Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	-	-
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>-</b>	<b>-</b>

### 3.7 Бусад орлого

Үзүүлэлт	Өмнөх он	(мян.төг) Тайлант он
Бусад орлого	5,825.0	-
<b>Нийт дүн</b>	<b>5,825.0</b>	<b>-</b>

### **3.8 Бусад зардал**

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	(мян.төг)
Үйл ажиллагааны бус зардал	5,821.8	-	-
<b>Нийт дүн</b>	<b>5,821.8</b>	-	-

### **3.9 Орлогын татварын зардал**

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	(мян.төг)
Орлогын татварын зардал	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	-	-

### **3.10 Холбоотой талуудын ажил гүйлгээ**

Санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу "Холбоотой талын тодруулга"-д тодорхойлсноор хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийвдэр гаргалтанд нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үзнэ гэж заасны дагуу холбоотой талуудын мэдээллийг татварын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тайлагнах үүрэгтэй

### **3.11 Балансын дараах үйл явдал**

2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр хүртэл Улаансан ХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулах шаардлагатай үйл явдал гараагүй байна.

Ахлах аудитор

Ш.Уянга

2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр